

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

2015 оны эхний хагас жилийн
үйл ажиллагааны тайлан

Тайланг хүлээн авагч:

Төсвийн ерөнхийлөн захирагч
Хууль зүйн сайд

Д.ДОРЛИГЖАВ

Улаанбаатар хот
2015 он

ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

Нэг. Ерөнхий тойм

- 1.1. Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд
- 1.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ын хүрээнд
- 1.3. Улсын бүртгэлийн архивын цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд
- 1.4. Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд
- 1.5. Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд
- 1.6. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд
- 1.7. Сургалт, гадаад харилцааны ажлын хүрээнд
- 1.8. Хүний нөөцийн ажлын хүрээнд
- 1.9. Санхүү, аж ахуй, хангамж үйлчилгээний ажлын хүрээнд
- 1.10. Мэдээллийн технологи, програм хангамжийн ажлын хүрээнд
- 1.11. Үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд

Хоёр. Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаа

- 2.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд
- 2.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд

Гурав. Бүртгэлийн хяналт, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үйл ажиллагаа

- 3.1. Бүртгэлийн хяналтын ажлын хүрээнд
- 3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын хүрээнд

Дөрөв. Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

- 4.1. Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд
- 4.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл гомдол, шийдвэрлэлтийн ажлын хүрээнд

Тав. Дүгнэлт

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРСНХИЙ ГАЗРЫН 2015 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

НЭГ. ЕРӨНХИЙ ТОЙМ

2015 онд тус газар нь хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг болон бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Жендэрийн тэгш байдлыг хангах” үндэсний хөтөлбөр, “Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөр, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах” үндэсний хөтөлбөр, “Агаарын тээврийг хялбаршуулах” үндэсний хөтөлбөр, “Цахим засаг” үндэсний хөтөлбөр, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлого” баримт бичигт тусгагдсан тус газрын чиг үүрэгт хамаарах арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн архивын цаасан суурьт нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, боловсронгуй болгох, зардал, шат дамжлагыг багасгах зорилт тавин ажиллаж байна.

Энэхүү зорилтын хүрээнд хуульд заасан бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн хөтлөх улсын бүртгэлийн хууль тогтоомжийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын цаасан суурьт нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай болгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөн, тайлангийн хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1.1. Хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Иргэний бүртгэлийн тухай, Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төслийг боловсруулах, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарсантай холбогдуулан хууль сурталчлах, шинэ хуулийг хэрэгжүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр:

“Хууль зүйн Сайдын 2014 оны А/12, А/19 тоот тушаалын дагуу “Иргэний улсын бүртгэлийн тухай хууль”-ийн төслийг боловсруулах ажлын хэсэгт тус газраас холбогдох албан хаагчид орж ажилласан бөгөөд хуулийн төсөлд санал авах зорилгоор байгууллагын цахим хуудсанд төслийн сүүлийн хувилбарыг байршуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Хууль зүйн сайдын өгсөн чиглэлийн дагуу хуулийн төсөлтэй холбогдуулан зарим төрлийн судалгаа хийсэн. Тухайлбал: Тээгч эх, үрчлэлт, эцэг тогтоолт, хүүхдийг эхээр овоглох, шилжилт хөдөлгөөний бүртгэлийг гадаад улсын хуулиар хэрхэн зохицуулж байгаа талаар судалгаа хийж, төв, орон нутгийн улсын бүртгэлийн газар хэлтсээс үрчлэлт хүчингүй болгосон, гэрлэлт сэргээсэн, хүйс өөрчлөгдсөн, хүн амын өрхийн бүртгэл, улсын бүртгэлийн

нэгж бүрийн ажлын ачааллын талаарх мэдээ, судалгааг авч нэгтгэн, хуулийн ажлын хэсгийг мэдээллээр ханган ажилласан.

“Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахимаар болон шуудангаар хүлээн авч, бүртгэх ажлыг эхлүүлэх” ажлын хүрээнд “Төрсний бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авах, бүртгэх журам”-ыг боловсруулан батлаад байна.

Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд хэрэглэх иргэний үнэмлэхийн дотоодод ашиглагдах хүсэлт, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газраар дамжуулан иргэний үнэмлэх захиалах хүсэлтийн загварыг газрын даргын №1813 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.

Газрын даргын 567 тоот тушаалаар ИБМУТ-ийн даргын 2011 оны 19 дүгээр тушаалаар батлагдсан “Иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагаас үндэсний энгийн гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох технологи ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт орууллаа.

Хууль зүйн яамны төрийн нарийн бичгийн даргын 2014 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн А/80 дугаар тушаалаар байгуулагдсан “Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспортыг чиптэй цахим паспорт болгох, түүнийг хэрэглээнд нэвтрүүлэх, холбогдох дүрэм, журамд өөрчлөлт оруулах тухай” теслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна.

Сонгуулийн тухай хуулийн төслийг судлан үзэж хуулийн төсөлд оруулах санал боловсруулж, УИХ дахь ажлын хэсэгт хүргүүлсэн. Дээрх ажлын хүрээнд хүчин төгөлдөр үйлчилж байгаа сонгуулийн хуулиудад харьцуулсан судалгааг хийж нэгтгэсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр:

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, бусад 28 хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг Улсын Их Хурлаас 2015 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр баталж, 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор Хууль зүйн сайдын тушаалаар “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”, “Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам”, “Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам”, “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам” гэх 4, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар “Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам” гэх 1 нийт 5 журам, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар 12 маягтын загварыг шинэчлэн баталж мөрдөж эхэлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:

“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд танилцуулж, Засгийн газраас УИХ-ын чуулганд өргөн барьсан. Хуулийн шинэчилсэн найруулгыг байгууллагын <https://burtgel.gov.mn> сайтад байршуулсан. Хуулийн шинэчилсэн найруулга батлагдан гарснаар эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг олон улсын жишигт нийцүүлэн бүртгэх, бүртгэлийн үйл ажиллагаанд зарчмын шинэ өөрчлөлтийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Мөн тус газрын үйл ажиллагаатай холбоотой “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль”-ийн төсөлд оруулах санал боловсруулж, хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт хүргүүлсэн ба уг хуулийн төсөл боловсруулсан ажлын хэсэг төслийг УИХ-ын чуулганаар хэлэлцүүлэхээр өргөн бариад байна.

Газрын тухай багц хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт тус газрын дарга, ахлах бүртгэгч нар ажиллаж хэлэлцүүлэг зохион байгуулан Газрын тухай хуулийн төслийн нийтлэг үндэслэл, хуулийн үзэл баримтлалд оруулах саналыг хүргүүлсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийг цахим систем (ePRS)-д хөтлөх журамд өөрчлөлт оруулж баталсан.

Бусад:

Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2012 оны 143/836 дугаар хамтарсан тогтоол/тушаалаар батлагдсан “Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах, түүнд өөрчлөлт оруулах тухай журам”-д ээлжит бус, нөхөн сонгууль явуулахад Сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах, нягтлан шалгахтай холбоотой харилцааг нэмж тусгасан нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, батлуулан Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр танилцуулга, нөлөөллийн шинжилгээг хийж Хууль зүйн яаманд хүргүүлэв.

Шилэн дансны хууль 2015 оны 1 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтэст хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх чиглэлийг, хуулийг хэрэгжүүлж ажиллах аргачилсан зөвлөмжийн хамт боловсруулж хүргүүлсэн.

Засгийн газрын 2013 оны 410 дугаар тогтоолоор батлагдсан “Цахим тоглоомын газрын үйл ажиллагааг зохицуулах журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тогтоолын төсөлд санал боловсруулж, хүргүүлэв.

Улсын бүртгэл, түүнтэй холбоотой бусад үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналыг төв, орон нутгийн нэгжээс авч, нэгтгэх ажиллагааг эхлүүлээд байна.

1.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ -ийн хүрээнд:

Улсын Их Хурлаас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр баталж, 03 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөж байна.

Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсантай холбогдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон бусад 28 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, түргэн шуурхай, боловсронгуй болгох чиглэлээр дараах асуудлуудыг тусгаж улсын бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байна. Үүнд:

1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай (шинэчилсэн) хуульд:

- Монгол Улсад хуулийн этгээд шинээр байгуулсан, өөрчлөн байгуулсан, татан буулгасныг болон хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлийн мэдээллийн санд бичгээр болон цахим хэлбэрээр бүртгэх, хуулийн этгээдийн бүртгэл хариуцсан байгууллагын чиг үүргийг тодорхой болгох, эрх хэмжээг тодорхойлох, хуулийн этгээд цахим гэрчилгээтэй байх, хуулийн этгээдийн улсын бүртгэл болон хувийн хэрэг хөтлөх, лавлагаа олгохтой холбогдон үүсэх харилцааг цогц байдлаар зохицуулахаар тусгасан.
- Хуулийн этгээдийн бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгох зорилгоор соёл, боловсрол, сургалтын болон эрүүл мэндийн байгууллагын бүртгэлийг тусгай зөвшөөрөл олгодог төрийн захиргааны төв байгууллага нь бүртгэдэг зохицуулалтыг өөрчилж хуулийн этгээдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүртгэхээр тусгасан.
- Энэ хуулиар улсын бүртгэлийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх, ашиглах үйл ажиллагаанд хяналт тавьж, лавлагаа олгохоор тусгасан.
- Дагалдан өөрчлөгдөж байгаа 28 хуулийн нэр томъёог энэ хуульд нийцүүлж, зарим хуульд нь нэмэлт өөрчлөлт оруулсан нь иргэн, хуулийн этгээд энэхүү хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хялбар болсон.

2. Хуулийн этгээдийн бүртгэлийн цахим хэлбэр:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад хуулийн этгээдийн нэрийг онлайнгаар илгээж, баталгаажуулах зохицуулалтыг тусгасан бөгөөд өргөдлийг цахимаар гаргах, үүнд хуулийн этгээдийг бүртгүүлэх өргөдөл, шаардагдах баримт бичгийг цахимаар илгээж, бүртгүүлэх боломжийг бүрдүүлсэн.
- Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх програм хангамжийг Үндэсний дата төвийн төслөөр “Инносолюшн” ХХК хийсэн. Энэ програм нь онлайнгаар хуулийн этгээдийн нэр шинээр авах, хуулийн этгээд шинээр бүртгүүлэх, хуулийн этгээдийн бүртгэлд засвар өөрчлөлт оруулах, үйлчилгээ авах цаг товлох бүрдүүлбэртэй.
- Хуулийн этгээдийг бүртгэх хугацааг багасгасан: Хуулийн этгээдийн бүртгэлийг ажлын 2 өдөр /гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж ажлын 10 өдөр/-ийн дотор бүртгэх шийдвэр гаргаж, цахим гэрчилгээг өргөдөл гаргагчдад цахим хэлбэрээр илгээх, хүссэн үедээ хэвлэх боломжтой болсон.
- 2015 оны 03 сарын 01-ний өдрөөс эхлэн <https://burtgel.gov.mn> цахим хуудсаар дамжуулан иргэдэд хуулийн этгээдийн нэр шалгах, захиалах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах үйлчилгээг тус тус үзүүлж байна.

3. Мэдээллийн ил тод байдал:

- Энэ хуульд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сан дахь мэдээллийг ил тод, нээлттэй байлгахгаар тусгасан. Өөрөөр хэлбэл улсын бүртгэлийн байгууллагын цахим хуудсанд байршуулсан хувь хүн, байгууллагын нууцад хамаарахаас бусад хуулийн этгээдийн мэдээллийг албан ёсны мэдээлэл гэж үзэхээр болсон.

4.Цахим гэрчилгээ:

- Улсын бүртгэлийн байгууллага нь өргөдөл гаргагчийн хүсэлтээр улсын бүртгэлийн гэрчилгээг үнэт цаасан дээр хэвлэж, баталгаажуулан олгож болно. Төрийн болон бусад байгууллага үйл ажиллагаандаа хуулийн этгээдийн цахим гэрчилгээг ашиглахаар тусгасан. Жишээлбэл, ТҮЦ машинаас гэрчилгээг авч болохоос гадна гэрчилгээг цахим байдлаар хүссэн үедээ хаанаас ч энгийн цаасан дээр хэвлэх боломжийг нээсэн. Ингэснээр улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн тохиолдолд шинээр гэрчилгээ авах, гэрчилгээг нотариатаар гэрчлүүлэн төрийн болон бусад байгууллагад өгөх шаардлагагүй болсон.

5.Бүртгэлийн хөнгөвчилсөн үйлчилгээ:

- Хуульд хуулийн этгээдийн бүртгэлийг улсын бүртгэгч гараар хөтөлдөг байсныг өөрчилж, цахим хэлбэрээр хөтлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Өөрөөр хэлбэл, бүртгэлийн дотоод үйл ажиллагааны цаг шаардсан, шаардлагагүй ажилбарыг халснаар бүртгэлийн ажилтнууд нь иргэн, хуулийн этгээдэд шуурхай үйлчлэх боломж бүрдсэн.
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13 дугаар зүйлийн 13.1-д "...гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг ажлын 10 өдрийн дотор, бусад хуулийн этгээдийг ажлын 2 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгэх эсэх талаар шийдвэр гаргаж, энэ тухай өргөдөл гаргагчид бичгээр, цахим хэлбэрээр мэдэгдэнэ." гэж зааж өгсний дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслийг ажлын 2 өдөрт багтаан улсын бүртгэлд бүртгэж байна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх баримт бичгийн тоо 2015 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2-оор багассан.

6.Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага:

- Улсын бүртгэлийн байгууллага болон иргэн, хуулийн этгээд нь хуульд заасан хугацаанд улсын бүртгэлд бүртгээгүй, бүртгүүлээгүй бол энэ хуульд хариуцлагын асуудлыг тодорхой тусгаж өгсөн.

7.Шинэчилсэн хуулийн сурталчилгаа:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг мөрдөж эхлэхээс өмнө АНУ-ын Монгол дахь Худалдааны танхим, Бизнесийг дэмжих санаачилга төслийн нэгжтэй хамтран дараах хэлэлцүүлгийг төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хамтран хийлээ.
 1. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам;
 2. Хуулийн этгээдийн нэр олгох, баталгаажуулах журам;
 3. Гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлд бүртгэх журам.
- Хэлэлцүүлгийн үеэр гарсан саналуудыг нэгтгэн журмын төсөлд Хууль зүйн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тусгах ажлыг зохион байгууллаа.
- Дээрх 3 журам болон иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын төслийг ажлын хэсэг

боловсруулж Хууль зүйн сайдын тушаалаар батлуулж, Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн мөрдөж байна.

- Мөн газрын даргын тушаалаар “Хуулийн этгээдийн хувийн хэрэг хөтлөх журам”, “Маягт, индекс, баталгааны тэмдгийн загвар”-ыг шинэчлэн баталж байгууллагын цахим хуудсанд байршууллаа.
- Хуулийн этгээдийн бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг гаргаж цахим хуудсанд байршуулсан.

1.3. Улсын бүртгэлийн архивын цаасан суурьт нотлох баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн архивын цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх зорилготой “Улсын бүртгэл, мэдээллийн нэгдсэн системийг сайжруулах цахим архив” төслийн хүрээнд хадгаламжийн нэгжүүдийг хооронд нь нэгтгэх, хуудсыг дугаарлах, иргэний бүртгэлийн /ХААТР/ маягтуудыг нэгтгэх, хадгаламжийн нэгжүүдийн хуудсуудыг тусгай програмын тусламжтайгаар цахим хэлбэрээр хуулбарлан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавин, хувийн хэрэгжүүлсэн нэгжийг дугтуйлах, дугтуйлагдсан хадгаламжийн нэгжийг товьёоглох, кодлох, хавтсанд хийж хадгаламжийн нэгж үүсгэх, хадгаламжийн нэгжийг буцаан байрлуулах зэрэг ажлуудыг үргэлжлүүлэн хийж байна. Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн сангийн цахимжуулалт 100 хувь, нэгдсэн сангийн цахимжуулалт 23.02 хувьтай явагдаж байгаа бөгөөд нийт 2 сангийн цахимжуулалт 61.51 хувьтай хийгдэж цахимжуулалтын ажил үргэлжилж байна.

Улсын бүртгэл мэдээллийн нэгдсэн системийг боловсронгуй болгох “Цахим архив” төслийн хүрээнд нийслэлийн болон орон нутгийн хуулийн этгээдийн хувийн хэргийн баримтыг цахимжуулах ажил бүрэн дууссан.

Цахимжуулалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор “Цахим хурд” аяныг зохион байгуулж, газрын даргын 690 тоот тушаалын хүрээнд албан хаагчдыг уртасгасан цагаар ажиллуулж байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын цаасан баримтын цахимжуулалт хийгдээгүй 13 аймагт цахимжуулалт хийхэд шаардлагатай төсөв зардлын судалгааг аймаг орон нутгаас ирүүлсэн судалгаанд үндэслэн гаргасан. Эдгээр 13 аймгаас орон нутгийн хөгжлийн сангаас Баян-Өлгий аймаг 50 сая, Баянхонгор аймаг 25 сая, Өмнөговь аймаг 20 сая төгрөг шийдүүлсэн байна.

2015 оны 04 дүгээр сарын 08-аас Баянхонгор аймагт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын 12667 хувийн хэргийг цахимжуулах ажлыг эхлүүлж өөрсдийн дотоод нөөц бололцоо, албан хаагчдын зүтгэлээр цахимжуулалтын ажлыг дуусгаснаар Баянхонгор аймагт 6 дугаар сараас эхлэн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн цахим үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

1.4. Улсын бүртгэлийн үйлчилгээг хялбаршуулж, түргэн шуурхай, боловсронгуй болгох ажлын хүрээнд:

Улсын бүртгэлийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх ажлын хүрээнд 2015 оны эхний 5 сарын хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- **Хуулийн этгээдийн бүртгэлийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэх.**

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдаж, энэ оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын <https://burtgel.gov.mn/> цахим хуудас, хуулийн этгээдийн цахим бүртгэлийн програм хангамжийг ашиглан иргэдэд хуулийн этгээдийн нэр шалгах, захиалах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах үйлчилгээг тус тус үзүүлж байна. Хуулийн этгээдийн цахим бүртгэлийн үйлчилгээ үзүүлж эхэлснээс хойш 5 дугаар сарын байдлаар дунджаар 2000 гаруй хүсэлтийг хүлээн авч бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн.

- **Төрийн үйлчилгээний цахим /ТҮЦ/ машинаар улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх.**

ТҮЦ машинаар иргэний бүртгэлийн 6 төрлийн лавлагаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн түүхчилсэн лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн дэлгэрэнгүй болон хуулийн этгээд бүртгэлгүй тухай лавлагаа олгох, хаяж гээгдүүлсэн, хүчинтэй байдлыг алдагдуулсан иргэний үнэмлэх дахин авах хүсэлтийг цахим хэлбэрээр хүлээн авч шийдвэрлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. 2015 оны эхний 5 сарын хугацаанд нийт улсын бүртгэлийн 390404 лавлагааг ТҮЦ машинаар иргэдэд олгож, 9948 иргэний үнэмлэх дахин авах хүсэлтийг ТҮЦ машинаар хүлээн авч шийдвэрлэсэн байна.

- **Улсын бүртгэлийн байгууллагаас олгох баримт бичгийг шуудангийн сүлжээгээр дамжуулан “Гараас гарт хүргэх” үйлчилгээ:**

“Монгол шуудан” ТӨХК-тай хамтран хэрэгжүүлж буй “Гараас гарт хүргэх” шуудангийн үйлчилгээг өргөжүүлж, Монгол Улсын Үндэсний энгийн гадаад паспортоос гадна Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэм, холбогдох баримт бичиг, эд хөрөнгийн гэрчилгээг шуудангийн сүлжээгээр дамжуулан иргэдэд хүргэдэг болсон. Тайлангийн хугацаанд нийт 6703 иргэний гадаад паспорт, 383 хуулийн этгээдийн гэрчилгээ, дүрэм, холбогдох баримт бичгийг иргэн, хуулийн этгээдийн хаягаар шуудангаар хүргээд байна.

- **Хүн амын төвлөрөл ихтэй сумдад эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх:**

Тус газрын цахим мэдээллийн санг ашиглан Сэлэнгэ аймгийн Сайхан, Мандал, Баянгол, Сант, Орхон, Орхонтуул, Баруунбүрэн 7 сумын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг Сайхан, Мандал сумаас бүсчилсэн хэлбэрээр, Завхан аймгийн Тосонцэнгэл сумын иргэдэд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн бүх төрлийн үйлчилгээг үзүүлдэг болсон.

Энэхүү байдлыг үргэлжлүүлэн энэ онд Төв аймгийн Лүн сумаас эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг хүргэж эхлээд байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг орон нутагт аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс үзүүлдэг байсныг тус газрын даргаас чиглэл өгсөний дагуу анхны бүртгэлийн үйлчилгээг сумаас үзүүлж байна. Он гарснаар эхний 5 сарын хугацаанд 6794 мэдүүлгийг суманд хүлээн авсан байна.

- **Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг түргэн хугацаанд хийх:**

Тус газрын даргаас холбогдох нэгжүүдэд чиглэл хүргүүлсний дагуу эд хөрөнгийн эрхийн анхны бүртгэлийг 14 хоногийн дотор бүртгэдэг байсныг ажлын 5 хоногийн дотор, эд хөрөнгө өмчлөх эрх гэрээ, хэлцлийн үндсэн дээр шилжсэнийг 7 хоногийн дотор бүртгэдэг байсныг ажлын 3 хоногийн дотор, яаралтай үйлчилгээний хөлс төлсөн барьцааны гэрээг ажлын 8 цагийн дотор бүртгэдэг байсныг ажлын 4 цагийн дотор тус тус улсын бүртгэлд бүртгэж байна.

- **Хорооноос үзүүлж буй улсын бүртгэлийн үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх:**

Тус газрын дарга, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн дагуу 2014 онд нийслэлийн 52 хороог онлайн сүлжээнд холбон үйлчилгээ үзүүлж байсан бол энэ онд нийслэлийн 83 хороог иргэний бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбож, хорооноос 7 төрлийн үйлчилгээ үзүүлдэг байсныг 10 болгож нэмэгдүүлсэн.

- **Гадаад паспортын мэдүүлгийн хуудсыг програмаас хэвлэх:**

Үндэсний энгийн гадаад паспорт шинээр захиалах хүсэлт гаргаж буй иргэн бүртгэлийн байгууллагад ирж олон асуулт бүхий мэдүүлгийн хуудсыг бөглөдөг байсныг өөрчилж иргэний хурууны хээний бүртгэлийг уншуулж, тухайн иргэний анкетийг хэвлүүлэн иргэнээр уншуулж хянуулан, гарын үсэг зуруулах үйлчилгээг нэвтрүүлсэн. Ингэснээр иргэд цаг алдалгүй үйлчилгээ авах бололцоо бүрдсэн.

- **Хүн амын төвлөрөл, ажлын ачаалал ихтэй нэгжийн орон тоог нэмэгдүүлэх:**

Тус газрын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөнтэй холбогдуулан тус газрын 2015 оны “Албан тушаалын орон тоо, ангилал, зэрэглэл батлах тухай” 387 дугаар тушаалаар нийслэлийн Улсын бүртгэлийн газар, дүүргийн Бүртгэлийн хэлтсийн орон тоог баталсан. Уг тушаалаар хүн амын төвлөрөл, ажлын ачаалал ихтэй Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн Бүртгэлийн хэлтсүүдэд улсын бүртгэгч нарын орон тоог, Баянзүрх, Сонгинохайрхан, Баянгол дүүргийн Бүртгэлийн хэлтсүүдэд хяналтын улсын байцаагчийн орон тоог ачаалал багатай нэгжээс шилжүүлэх байдлаар тус тус нэмэгдүүлсэн.

- **Байгууллагын үйл ажиллагааг түргэн шуурхай болгох:**

Байгууллагын мэдээлэл солилцооны хурдыг нэмэгдүүлэх, шуудан, бичиг хэргийн зардлыг бууруулах зорилгоор байгууллагын үйл ажиллагаанд e-Office системийг нэвтрүүлэх тухай УБЕГ-ын даргын тушаалаар дотоод сүлжээнд хэрэглэх боломжийг бүрдүүлсэн e-Office системийг УБЕГ, НУБГ, 21 аймаг, 9 дүүргийн нийт 864 хэрэглэгчдийг хамруулан ашиглалтанд оруулж ашиглаж хэвшээд байна.

1.5. Аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийг нөхөн сонгох сонгуулийг зохион байгуулах ажлын хүрээнд

Аймаг, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд заасан улсын бүртгэлийн байгууллагын чиг үүргийн дагуу Булган аймгийн Булган сумын Хужирт баг, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр баг мөн тус сумын 1, 2, 3, 6 дугаар баг, Баян-Өлгий аймгийн Өлгий сумын 5 дугаар баг, Увс аймгийн Өлгий сумын Улиаст багт нөхөн сонгууль явуулах ажлыг зохион байгуулахад оролцон ажиллаж байна. 2015 оны эхний хагас

жилийн байдлаар 4 аймгийн 5 суманд Аймаг, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль товлогдож, 2 суманд нөхөн сонгууль амжилттай явагдаж дууссан.

Энэхүү ажлын хүрээнд:

- Сонгуулийн ажлыг зохион байгуулах төлөвлөгөө боловсруулах;
- Иргэний шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох тухай газрын даргын тушаал төлөвлөж батлуулах;
- Улсын дээд шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газруудаас хуульд заасан холбогдох мэдээллийг авах;
- Сонгогчдын нэрсийн жагсаалт гаргах, хэсгийн мэдээллийг тулган шалгах;
- Сонгогчдын нэрсийн жагсаалтыг байгууллагын вэб сайтад байршуулах;
- Сонгогчдын нэрсийн жагсаалтыг цаасан болон цахим хэлбэрээр хэсгийн хороонд хүргүүлэх ажиллагаанд хяналт тавих;
- Орон нутагт дахь салбар, нэгжийг мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, тулгамдсан шаардлагатай асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэж байна.

Мөн Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 1 дүгээр баг мөн тус сумын 1, 2, 3, 6 дугаар багт энэ оны 04 дүгээр сарын 22, 05 дугаар сарын 03-ны өдөр, Увс аймгийн Өлгий сумын Улиаст багт энэ оны 04 дүгээр сарын 24-ний өдөр тус тус аймаг сумын ИТХ-ын тогтоол гарсантай холбогдуулан сонгууль зохион байгуулах ажлыг орон нутгийн бүртгэлийн хэлтэст чиглэл хүргүүлэн, холбогдох арга хэмжээг авч ажилласан.

1.6. Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд:

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлого” баримт бичиг, Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журмыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

Байгууллагын шийдвэр, үйл ажиллагааг олон нийтэд таниулах, сурталчлах чиглэлээр:

Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний мэдээллийн нээлттэй, ил тод, шуурхай байдлыг хангах зорилтын хүрээнд Улсын бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээ, хууль тогтоомжийн хэрэгжилт бусад цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд цаг тухайд нь хүргэж, сурталчилан тус газрын удирдлага, албан тушаалтнууд нэвтрүүлэг, ярилцлагад оролцсон.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үйлчилгээг анхан шатны нэгжээс хүргэж эхэлсэн талаар болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, хуулийн этгээдийн онлайн үйлчилгээ, бусад цаг үе, үйл явдлын арга хэмжээг сурталчлах хүрээнд тайлант хугацаанд нийт **41** хэвлэл мэдээллийн хэрэгслээр давхардсан тоогоор **82** удаагийн сурталчилгааг телевиз, мэдээллийн цахим сайт, өдөр тутмын сонингоор дамжуулан олон нийтэд хүргэхээс гадна телевиз, радиогийн нийт **15** нэвтрүүлэгт оролцсон байна.

Мөн Монголын FM-үүдийн холбоотой хамтран ажиллах хүрээнд 1, 2, 3 дугаар саруудад FM107.5 радиогийн “Бүртгэл ба хууль” 30 минутын ярилцлагын нэвтрүүлэгт холбогдох газрын дарга нар оролцсон.

Шинээр батлагдсан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг сурталчлах зорилгоор нийт 17 хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ, ярилцлага өгч, холбогдох албан тушаалтан телевизийн 8 удаагийн нэвтрүүлэгт оролцсон.

Улсын бүртгэлийн байгууллагын 75 жилийн ойг угтсан ажлын хэсгийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд байгууллагын үй ажиллагааг сурталчлах дараах ажлуудыг тусган хэрэгжүүлж эхлээд байна. Үүнд:

- Нийт албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдааныг зохион байгуулсан.
- Бүртгэлийн байгууллагын нийт албан хаагчдын дунд гал түймрийн гамшигт өртсөн зүүн 3 аймгийн иргэдэд туслах зорилгоор “Сайн үйлсийн аян” өрнүүлж, иргэдийг бичиг баримтжуулах ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж байна.

Цахим хуудас, мэдээллийн самбараар дамжуулан иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлээр:

Дээрх эрх зүйн баримт бичгүүдийг хангаж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд болон бүтэц, орон тоо шинэчлэгдсэнтэй холбогдуулан байгууллагын <https://burtgel.gov.mn> цахим хуудас дахь шаардлагатай мэдээллийг дахин шинэчлэв.

Тайлант хугацаанд холбогдох хууль, дүрэм, журамд заасны дагуу цахим хуудсаар дамжуулан 23 цонхны нийт **414** мэдээллийг байршуулснаас шинээр **322**-г оруулсан бол **92** мэдээллийг шинэчилж /хуучинг сэргээж/ мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж ажилласан.

Мөн иргэд болон бүртгэлийн ажилтныг хууль, эрх зүйн мэдээллээр хангахтай холбогдуулж тайлант хугацаанд байгууллагын цахим хуудаст шинээр УИХ-аар баталсан хууль **1**, Хууль зүйн сайдын тушаалаар **4**, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалаар **7**, нийт **12** дүрэм журам, заавар шинэчлэн байршуулсан.

Иргэний болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль-шинэчилсэн найруулгын төслийг олон нийтийн санал асуулгаар хэлэлцүүлэхээр байгууллагын цахим хуудаст нийт **8** удаагийн зарыг байршуулсан.

Төсөв санхүүгийн ил тод, нээлттэй байдал: Шилэн дансны тухай хуулийг 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн орон даяар мөрдөж эхлэхтэй холбогдуулан бүртгэлийн ерөнхий газрын цахим хуудсанд “Шилэн данс” цэсийг үүсгэн www.shilendans.gov.mn сайттай холбох ажлыг зохион байгуулав. Энэхүү ажлын хүрээнд Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсүүдийн бүртгэл үүсгэн, холбоосын тохиргоо хийж холбогдох дансны мэдээллийг оруулах боломжийг бүрдүүлж хуулинд заасан мэдээллүүдийг хугацаанд нь оруулсан.

Хуульд заасны дагуу байгууллагын мэдээллийн самбар болон цахим хуудаст Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, 2015 оны төсөв, төсвийн байгууллагын санхүүжилтийн **1-5** дугаар сарын тайлангийн талаарх нийт **6** мэдээллийг шинэчлэн байршуулсан.

Хүний нөөцийн ил тод, нээлттэй байдал: Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмаас гадна Төрийн албаны салбар зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөл, тус газрын хүний нөөц, ёс зүйн хороо, харьяа газар, хэлтсийн **7** цэсийг тус тус шинээр вэб холбоос үүсгэв.

Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдал: Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2014 оны бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын тухай тайлан болон тус газраас зарласан 5 тендерийн урилгыг байгууллагын цахим хуудас мэдээллийн самбарт тус тус байршуулсан. Мөн өдрийн сонин, өнөөдөр сонинд зарлаж олон нийтэд мэдээлэв.

1.7. Сургалт, гадаад харилцааны ажлын хүрээнд:

Сургалтын чиглэлээр:

Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдын тасралтгүй сургалтын нэгдсэн хөтөлбөр, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, сургалт, семинар зохион байгуулах замаар албан хаагчдын мэдлэг чадавхийг дээшлүүлж, мэргэжил арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах зорилтын хүрээнд 2015 оны эхний хагас жилийн байдлаар 20 гаруй сургалт, семинар зохион байгуулж давхардсан тоогоор 549 албан хаагчдыг хамруулаад байна. Зохион байгуулсан сургалт семинараас дурдвал:

- Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны нэгдсэн сургалт, зөвлөгөөн;
- Байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдөх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сэтгэл зүй, дохионы хэлний анхан шатны сургалт;
- Улсын бүртгэгч бэлтгэх сургалт буюу ажлын байранд бэлтгэх сургалт;
- Сургагч багш бэлтгэх сургалт;
- Иргэний болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын анхан шатны сургалт;
- Хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарын нэгдсэн сургалт;
- Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн ахисан шатны сургалт;
- Хяналт, шинжилгээ дотоод аудитын чиглэлийн сургалт;
- Компьютерийн хэрэглээний програмын сургалт;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт;
- Албан хэрэг хөтөлөлтийн стандартын сургалт;
- Хүний нөөцийн чиг хандлага, Төрийн албаны хүний нөөцийн удирдлага сургалт;
- Авлигаас урьдчилан сэргийлэх сургалт;
- Хүний эрхэд суурилсан хандлага;
- Онлайн сургалтад бүртгэлийн бүх чиглэлээр болон албан хаагчдын эрүүл мэнд, амралт чөлөөт цагт зориулсан сургалтуудыг нийтэд болон албан хаагчдад гэсэн ангиллаар сургалтуудыг зохион байгуулав.

Мөн Эдийн засгийн хөгжлийн яам, Хууль зүйн яам, Үндэсний статистикийн хороо, Удирдлагын академийн мэргэжил дээшлүүлэх институт, Мэдээллийн технологийн Үндэсний парк, бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтад тус газрын холбогдох албан хаагчдыг хамруулсан. Үүнд:

- Санхүүгийн албан хаагчдын мэргэжил дээшлүүлэх сургалт;
- Юник Легаль Партнерс хуулийн фермтэй хамтран төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад бэлтгэх сургалт;
- С болон Java хэлний ерөнхий мэдээлэл, андройд үйлдлийн систем хөгжүүлэх анхан болон дунд шатны сургалт;

- “Төрийн архивын баримтад иж бүрэн нягтлан шалгалт, дахин боловсруулалт хийх арга зүй” сэдэвт сургалт;
- Архивын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөн;
- Канадын олон улсын хөгжлийн агентлаг, төрийн байгууллагын хамтын ажиллагааны оролцоотой Өмнөговь аймагт зохион байгуулсан “Эрүүл мэнд, байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” сэдэвт 10 өдрийн сургалт.
- Улаанбаатар Эрдэм дээд сургуулийн эрх зүйн чиглэлээр бакалавар, магистрийн хөнгөлөлттэй сургалтад хамрагдах 8 албан хаагчийг бүртгэн мэдээлэл хүргэсэн.
- Удирдлагын академийн мэргэшүүлэх дипломын сургалтад албан хаагчдыг хамрууллаа.
- Монголын мэргэшсэн дотоод аудиторчуудын институтээс зохион байгуулдаг мэргэшсэн дотоод аудиторын эрх олгох сургалт.
- Эко клубын гишүүдэд мод зүлэг, ногоон байгууламж арчлах талаар анхан шатны мэдэгдэхүүн олгох сургалтыг “Ногоон төгөл” ХХК-ийн захирал Б.Гомботуяатай хамтран зохион байгуулсан.

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалт:

Улсын бүртгэлийн үйлчилгээ, үйл ажиллагааг сурталчлах, Иргэний болон Эд хөрөнгийн эрхийн, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай үндсэн ойлголт, төрлүүд, анхаарах асуудлын талаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрх зүйн ойлголт өгөх, тэдэнд төрийн үйлчилгээг хүргэх нөхцөл боломжоор хангахад чиглэгдсэн сургалтыг Сэргээн Засалт, Хөгжлийн Үндэсний төвд 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулав. Сургалтад Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагч, Сэргээн засалт, Хөгжлийн Үндэсний төвийн 30 орчим албан хаагчид хамрагдсан.

Орон нутагт зохион байгуулагдсан сургалт:

Эрх зүйн сургалт, сурталчилгааны хүрээнд:

Улсын бүртгэлийн алба үүсч хөгжсөний 75 жилийн ойг угтан зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан “Байгууллагын нэрэмжит туг” аялуулах аяныг 5 дугаар сарын 15-ны өдрөөс Архангай, Төв аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс эхлүүлээд байна. Энэхүү аяны хүрээнд туг хүлээн авсан газар, хэлтэс нь төлөвлөгөөний дагуу байгууллагын үйл ажиллагаа, бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд мэдээлэл хүргэх Нээлттэй хаалганы өдрийг зохион байгуулах ба өөрийн нөөц бололцоогоор шинэчилсэн дүрэм, журам, бүрдүүлэх материалын талаар тараах материал бэлтгэн иргэдэд хүргэн ажиллаж байна. 6 дугаар сарын 15-ны байдлаар Архангай, Төв, Өвөрхангай, Дундговь аймгийн бүртгэлийн хэлтсүүдэд дээрх арга хэмжээг зохион байгуулаад байна. Цаашид хуваарийн дагуу явагдаж УБЕГ болон Нийслэлийн улсын бүртгэлийн газарт 10 дугаар сард дээрх арга хэмжээ зохион байгуулагдана.

Мөн Баян-Өлгий, Булган, Дорноговь аймгийн 9 сумдад Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж нийтдээ 1754 гаруй иргэдэд төрийн үйлчилгээг хүргэсэн байна.

Иргэдэд зориулсан эрх зүйн сургалтын хүрээнд аймаг дахь бусад төрийн байгууллагын албан хаагчдад бүртгэлийн чиглэлээр мэдээлэл өгсөн ба тэдгээрийн зохион байгуулсан сургалтад албан хаагчдаа хамруулан ажиллалаа.

Гадаад харилцааны чиглэлээр

НҮБ - Ази Номхон далайн орнуудын Эдийн засаг, нийгмийн комиссоос хэрэгжүүлж буй Иргэний бүртгэл, хүн амын үндсэн статистик үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааг дэмжин ажиллах бүс нутгийн удирдах зөвлөлийн гишүүнээр тус газрын иргэний бүртгэлийн газрын даргыг, Монгол улсад дээрх үйл ажиллагааны талаар мэдээлэл түгээх, зохицуулах ажлыг хариуцах мэдээлэгч төв болж ажиллахаар УБЕГ-ыг тус тус нэр дэвшүүлэн НҮБ-ын Статистикийн хэлтэст хүргүүлж Иргэний бүртгэлийн газрын дарга 2015-2019 онд бүс нутгийн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгогдон ажиллахаар болсон.

Тайлант хугацаанд Европын Компанийн бүртгэлийн холбоо (ECRF) –оос явуулсан олон улсын компанийн бүртгэлтэй холбоотой судалгаа, Дэлхийн банкнаас “Бизнес эрхлэхүй 2016” төслийн хүрээнд Бизнес эрхлэгчдийн тухай судалгааг тус газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газартай хамтран хийж явуулсан.

Компанийн бүртгэлийн холбоо (CRF)-нд гишүүнчлэлээ сэргээх талаар албан хүсэлт хүргүүлж гишүүнчлэлээ баталгаажуулан сэргээсэн.

Бүгд Найрамдах Турк Улсын “Хүн ам, иргэний бүртгэлийн ерөнхий газар”-тай хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийн төслийг боловсруулж Гадаад хэргийн ямаар дамжуулан хүргүүлээд байна.

БНХАУ-ын Засаг захиргааны онцгой бүс Хонконгын Компанийн бүртгэлийн байгууллага болон ОХУ-ын Эдийн засгийн хөгжлийн яамны харьяа Улсын бүртгэл, кадастр, зурагзүйн газартай харилцаа холбоо тогтоох, цаашид хамтран ажиллах гэрээ байгуулах, туршлага солилцох хүсэлтийг Монгол Улсаас Хонконгт суугаа Ерөнхий консул болон Монгол Улсаас ОХУ-д суугаа Элчин сайдын ямаар дамжуулан холбогдох байгууллагад хүргүүлээд байна.

1.8. Хүний нөөцийн ажлын хүрээнд

Хууль зүйн сайдын 2015 оны “Бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, шинэчлэн батлах тухай” А/16 дугаар тушаалаар тус газрын бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан бөгөөд тус газар нь 1269 албан хаагчтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Тус байгууллагад ажиллаж байгаа 1269 төрийн албан хаагчаас эрэгтэй-384, эмэгтэй 885 албан хаагч ажиллаж, хүйсийн харьцаа 30:70 хувьтай байна. Байгууллагын хүний нөөцийн бодлогын хүрээнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд УБЕГ-н нийт албан хаагчдын хүйсийн тэнцвэрт байдал, цэргийн алба хаасан албан хаагчдын судалгааг Хууль зүйн яам болон Сүхбаатар дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабад тус тус гаргаж хүргүүлээ.

Тус газрын даргын тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ханган ажиллах хүрээнд:

- “Эх үрсийн баяр”-ыг тохиолдуулан албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг гардууллаа.

- “Улсын бүртгэлийн ерөнхий газрын улирлын шилдэг ажилтан шалгаруулах журам”-д заасны дагуу үйл ажиллагааны үр дүн, идэвхи санаачлага, ажлын ололт амжилт, бүтээлч

байдал, төрийн албан хаагчийн ёс зүй, нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, “Байгууллагын стандарт”-ыг мөрдөн ажиллаж байгаа 10 албан хаагчийг шалгаруулж батламж болон дагалдах мөнгөн шагналаар урамшуулав.

- Тус газрын болон нийслэлийн Улсын бүртгэлийн газрын төрийн захиргааны албан хаагчдын 2014 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, цаашид авах арга хэмжээний хүрээнд цалингийн шатлал ахиулах, зэрэг дэв шинээр олгох, ахиулах, төрийн алба хаасан хугацаа, нууцын, төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадвар, мэргэжлийн зэргийн нэмэгдэл олгуулахаар ирүүлсэн саналыг судалж Төрийн албаны Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж УБЕГ-ын даргын 2015 оны 700, 867, 868 дугаар тушаалаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгосон.

Тус газрын дэргэд байгаль орчноо хамгаалах, нөхөн сэргээх, мод тарьж ургуулах зорилготой “Эко клуб” байгуулан үйл ажиллагааг эхлүүлж, байгууллагын орчин, ногоон байгууламжийг сайжруулах төлөвлөгөө, төсөл боловсруулан хэрэгжүүлж, 150 гаруй мод суулган, зүлэг, цэцэг тарих ажлыг графикийн дагуу хийж эхлээд байна.

Мөн байгууллагын албан хаагчдын эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд эх орны амралт сувиллын судалгааг гаргаж, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын нутагт байрлах Хасу шивэрт сувилалтай гэрээ байгуулан, эхний 15 албан хаагчийг амрах ажлыг зохион байгуулав.

ХҮИ жарны модон хонь жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Улсын бүртгэлийн байгууллагад ажиллаж байсан 60 ахмад ажилтныг хүлээн авч, хүндэтгэл үзүүлсэн.

Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 94, Улсын бүртгэлийн байгууллага үүсгэн байгуулагдсаны 75 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээл гарган ажиллаж байгаа тус газрын 24 албан хаагчдыг төрийн дээд шагналаар шагнуулахаар нэрийг дэвшүүлж, холбогдох материалыг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Тус газрын албан хаагчдаас өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч төрийн албанаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан 2 албан хаагчид 26.419.700 төгрөгийн 1 удаагийн буцалтгүй тусламж олгож, судбаооёуя нобдөөоао айёий ао айуоёеи аа+еёааё, хүүхэд асрах, ёяйюоаүй зүюо ёаёоааиу оёлаааи +°е° авахыг ёяйүй 28 аёааи бааа+ийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа.

Тайлангийн хугацаанд тус газрын “Ёс зүйн хороо”-гоор 3 албан хаагчтай холбоотой асуудлаар 1 удаа хуралдаж холбогдох албан хаагчид авах арга хэмжээг авч ажилласан бөгөөд тус газрын дэргэдэх төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь тайлант хугацаанд 6 удаа хуралдаж, тус газрын ёс зүйн хороогоор орсон асуудлуудыг авч хэлэлцэн дүгнэлт гарган, төрийн албаны салбар зөвлөлд хандаж ирүүлсэн албан бичиг, өргөдөл хүсэлтэд хариу өгч ажилласан.

1.9. Санхүү, аж ахуй, хангамж үйлчилгээний ажлын хүрээнд

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан гаргаж, Үндэсний аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулан “Зөрчилгүй” санал, дүгнэлт авч, Хууль зүйн яаманд хугацаанд нь хүргүүлсэн.

Сангийн яамны “Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан” онлайн програмд 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Аймаг, Нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтэс тус бүрээр шивж оруулан, баталгаажуулан илгээсэн.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2014 оны санхүүгийн тайланд тусгасан өмч, хөрөнгийн мэдээллийг нэгтгэн ТӨХ маягтын дагуу гаргаж Төрийн өмчийн хороо болон Үндэсний статистикийн хороонд хугацаанд нь хүргүүлсэн.

Улсын бүртгэлийн байгууллагын төсвийн гүйцэтгэлийн 5 дугаар сарын мэдээгээр 5,6 тэрбум төгрөгийн үйлчилгээний орлогыг төвлөрүүлж, 2015 оны хагас жилийн орлогын төлөвлөгөөний биелэлт 96 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төсвийн хуваарь, төлөвлөгөөний дагуу хагас жилд 9.034.4 сая төгрөгийг зарцуулахаас 6.768.5 сая төгрөгийг зарцуулж, 74.9 хувийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд зарцуулагдаагүй үлдэгдэл нь үнэт цаас, маягт худалдан авах гэрээ болон тендерийн явцаас хамаарсан улсын мэдээллийн маягт хэвлэх, иргэний үнэмлэх хэвлэж тараах зардлын төсвийн үлдэгдэл юм. Мөн батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай, хэмнэлттэйгээр зарцуулж байна.

2016 онд сонгууль зохион байгуулагдахтай холбогдуулан одоогийн хүчин төгөлдөр мөрдөж буй хуулийн хүрээнд сонгуулийн зардлын төсвийг боловсруулж Сонгуулийн ерөнхий хороо болон Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Тус газрын 2015 оны буюу суурь оны төсөв дээр нэмэгдэх 2016 оны төсвийн хязгаарт өгөх саналыг боловсруулан Хууль зүйн яаманд хүргүүлсэн. Төсвийн хязгаарын саналд 2016 онд Монгол Улсын Их хурал болон Аймаг, сум дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдуулан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1, Аймаг, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10.1 дэх заалтад “Сонгууль зохион байгуулахтай холбогдсон үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ”, 10.5 дахь заалтын хүрээнд гарах зардал; иргэний цахим үнэмлэхийн бэлдэц худалдан авах зардал; эд хөрөнгийн бүртгэлийн сүлжээний кабелийн сувагчлалын зардал болон бусад нэн шаардлагатай урсгал зардал; иргэний цахим үнэмлэхийн хэвлэх үйлдвэрийн техник тоног төхөөрөмж, аюулгүй ажиллагааг хангах зардал; иргэний биеийн давхцахгүй өгөгдөл болох хурууны хээний дүрсийг таних, баталгаажуулах AFIS системийн лиценз; улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан бүхий серверийн тоног төхөөрөмж; Тагнуулын ерөнхий газар болон Кибер аюулгүй байдлын газраас хийсэн шалгалтын зөвлөмжийн дагуу хийгдэх мэдээллийн технологийн ажлын зардал; иргэний шинэчилсэн бүртгэлийн тоног төхөөрөмж; чиптэй Үндэсний энгийн гадаад паспортыг хэрэглээнд нэвтрүүлэх зардлын төсөв зэрэг 2016 оны төсөвт нэн шаардлагатай, тулгамдаж буй санхүүгийн асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай зардлын төсвийг тооцож тусгасан.

Хууль зүйн сайдын баталсан 2015 оны урсгал зардлаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй тендер 2, хязгаарлагдмал тендер 1-ийг 2015/103 өмд ӨААӨД 1а үд, өаа өааааааа ү хязгаарлагдмал өааааааааа шалгарсан компанитай ауйуу ааа өаа өаааа ажиллаж байна. 2015/104, 2015/105 өмд нээлттэй өааааааааа шаардлагад нийцсэн нэг ч тендер ирээгүй тул тендерээс татгалзаж, ааа өаа өааааааааа байна.

Үндэсний энгийн гадаад паспортын бэлдэц, иргэний цахим үнэмлэхийн бэлдэц нийлүүлэх гэрээг Хууль зүйн яамны зөвшөөрлийн дагуу нийлүүлэгч байгууллагуудтай байгуулсан. Үндэсний энгийн гадаад паспортыг гэрээний дагуу бүрэн хүлээн авч, төлбөр

тооцоог барагдуулсан. Иргэний цахим үнэмлэхийн бэлдэц гэрээний дагуу 7 дугаар сарын эхээр нийлүүлэгдэхээр байна.

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийг 3 удаа хуралдуулан, эргэлтийн хөрөнгө актлах, устгах асуудлыг шийдвэрлүүлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаал гаргуулан зохион байгуулж ажилласан.

2014 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр УБЕГ болон орон нутгийн бүртгэлийн хэлтсээс ирүүлсэн 187.679.2 мянган төгрөгийн анхны үнэ бүхий үндсэн хөрөнгийг “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн хяналт, Төрийн өмчийн хорооны 2015 оны 250 дугаар тогтоол, УБЕГ-ын даргын 2015 оны 880 дугаар тушаалын дагуу акталж, данснаас хассан.

Засгийн газраас хэрэгжүүлж байгаа бодлогын хүрээнд иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах зорилгоор нийслэл, орон нутагт суурилуулсан “Төрийн үйлчилгээний цахим машин”-ыг үнэт цаасаар ханган, үнэт цаасны төлбөр тооцоог тухай бүр хийж ажилласан.

1.10. Мэдээллийн технологи, програм хангамжийн ажлын хүрээнд

“Иргэний бүртгэлийн улсын нэгдсэн сүлжээ”, “Хөрөнгийн эрхийн төсөл”, “Иргэний шинэчилсэн бүртгэл”, “Иргэний цахим үнэмлэх”, “Хуулийн этгээдийн бүртгэлийн систем”, “Улсын бүртгэл, мэдээллийг сайжруулах цахим архив”, зэрэг төсөл, хөтөлбөрүүдийн харилцан уялдааг хангах, техник эдийн засгийн үндэслэлийг гаргах, бүртгэлийн үйл ажиллагааг хөнгөвчлөх технологийн шийдлийг гаргах, шаардлагатай ажлын хэрэгцээний програмыг шинээр болон шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулав.

НИТХ-ын 2013 оны 10/39 дүгээр тогтоолоор нийт 52 байршилд шинээр газар өмчлүүлэх ажлын 2 дугаар ээлжинд зарлагдсан 8 байршилд газар өмчлөх эрхийн нэгж талбарыг сонгох үйл ажиллагааг цахим хэлбэрээр бүртгэх бүртгэлийн ажилтай холбоотойгоор Нийслэлийн өмчийн харилцааны газраас ирүүлсэн 180 мянга гаруй иргэдийн мэдээллийг нягтлан шалгаж, хариу хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.8, Хууль зүйн сайдын 2015 оны А/42 дугаар тушаалын хавсралтаар баталсан иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журмын дагуу “Иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэг бүртгэлийн систем”-ийг шинээр боловсруулан бүртгэлийн цахим хуудсанд Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг гэмтээсэн, нэр, хэлбэр өөрчилсөн, ашиглалтын шаардлага хангахгүй болсон тохиолдолд хяналтын дугаар дахин авах, Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг үрэгдүүлсэн тохиолдолд хяналтын дугаар дахин авах, Тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн хяналтын дугаар шинээр авах зэрэг үйлчилгээний цэсийг вэб хуудсанд байршуулан хэрэглэгчийн гарын авлагыг боловсруулан үйлчилгээнд нэвтрүүлэв.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасны дагуу хуулийн этгээдийн мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх портал сайт болон тус газраас иргэдэд үзүүлдэг хуулийн этгээдийн нэрийг онлайнаар шинээр авах, хуулийн этгээдийг шинээр үүсгэн байгуулах, хуулийн этгээдийн мэдээлэлд нэмэлт өөрчлөлт оруулах, үйлчилгээний дарааллыг урьдчилан захиалах хүсэлт хүлээн авах, хуулийн этгээдийн гэрчилгээг онлайнаар харах агуулга бүхий үйлчилгээний вэб порталыг ажиллуулах талаар тагнуулын байгууллагад хандан холбогдох зөвшөөрлийг авч, хэрэглээнд нэвтрүүлсэн.

Иргэний биеийн давхцахгүй өгөгдөл гарын хурууны хээний 2010-2014 онуудад суурилуулсан нийт 2,050,000 ширхэг лицензийн ашиглалтын хугацаа дуусч, шинээр 16 насанд хүрсэн иргэдийг шинэчилсэн бүртгэлд хамруулах, хурууны хээний бүртгэлийн мэдээллийн давхардлыг шалгах асуудлаар Монгол Улсын хүн амын жилийн дундаж төрөлтийг 2015 онд 80 мянга орчим, лицензийн нөөц 20 хувь байхаар тооцож серверийн лицензийн тоог 100 мянган ширхэгээр нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа тухай болон энэхүү үйл ажиллагаатай холбоотой холбогдох зардлыг шийдвэрлүүлэх тухай танилцуулгыг боловсруулж Хууль зүйн яаманд хүргүүлэн зардлыг шийдвэрлүүлэв.

МТШХХГ, Кибер аюулгүй байдлын газар, Үндэсний дата төв УТҮГ-тай хамтарсан Цахим засаглал хуулийн төсөл боловсруулах, Засгийн газрын 212 дугаар тогтоолыг шинэчлэх санал боловсруулах Ажлын хэсэгт нэг албан тушаалтан ажиллаж байна.

Эд хөрөнгийн бүртгэлийн системд гарч байгаа алдаа болон шаардлагатай өөрчлөлт шинэчлэлтийн асуудлыг шийдвэрлэх талаар “Цахим архив” төслийн гүйцэтгэгч SK C&C компанийн мэргэжилтнүүдтэй хамтран мэдээлэл удирдах болон хуулийн этгээдийн цахимжуулалтын ажлын хөрвүүлэлтийг хийх алдааг засварлах асуудлаар 2015 оны 5 дугаар сард уулзалт хийж 4 өдөр хамтран ажилласан. Цаашид дээрх асуудлаар дэлгэрэнгүй хариуг 6 сард багтаан ирүүлэхээр тохиролцов.

Иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд шилжилт хөдөлгөөний мэдээллийг бичих, иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойгоос бичвэр, зурган мэдээллийг унших боломжтой шийдлийг боловсруулан бүртгэлийн нэгжүүдэд тараах, хэрэглээнд нэвтрүүлэхэд бэлэн болоод байна.

Мөн иргэний цахим үнэмлэхийн бичил санах ойд цахим гарын үсгийн IAS Classic V3 апплетыг идэвхжүүлэх, гарын үсгийн RSA 1024 бит криптограф бүхий PKI сертификат бичих, унших боломжийг бүрдүүлсэн. МШХХТГ-аас цахим гарын үсгийн хэрэглээтэй цахим гарын үсгийг үүсгэх, олгохтой холбоотой аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулалт хийгдсэний дараа хэрэглээнд нэвтрүүлэхээр бэлтгэж байна.

УИХ-ын 2012 оны 37, Засгийн газрын 2012 оны 70 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хоёр газрын хамтран байгуулсан “Хамтран ажиллах санамж бичигт” заасны дагуу 2015 оны эхний хагас жилд зургаан удаагийн актаар тус газрын мэдээллийн санд шинээр нэмэгдсэн, өөрчлөгдсөн, хасагдсан Монгол Улсын 18 хүртэлх насны 46755 иргэний мэдээллийг НХҮЕГ-т цахим хэлбэрээр хүргүүлэв.

Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас жагсаалтаар ирүүлсэн 0-18 хүртэлх насны 1119136 иргэний мэдээллийг тус газрын мэдээллийн сантай тулган шалгаж, мэдээллийн санд бүртгэлтэй 1105221, мэдээллийн санд бүртгэлгүй 11419, нас барсан 2242, харьяатаас гарсан 232, хүчингүй регистрийн дугаартай 22 иргэний мэдээллийг файл хэлбэрээр хүргүүлсэн.

Аймаг, сум, дүүргээс иргэний биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэлийн мэдээлэл бүхий дискийг хүргүүлэх, мэдээллийг санд тусгах, тулган нягтлах, баталгаажуулах зэрэг ажиллагааг хурдасгах, хугацааг хэмнэх зорилгоор тус газраас 21 аймгийн Улсын бүртгэлийн хэлтсээс шууд хандан өгөгдөл, мэдээллийг хуулбарлах боломж бүхий серверийг үүсгэн ашиглалтанд оруулаад байна.

Мэдээллийн хадгалалт, хамгаалалт, нууцлал, аюулгүй байдлыг хангах зорилгоор иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн мэдээллийг Үндэсний дата төв

УТҮГ-аар дамжуулан төрийн бусад байгууллагад ашиглуулахдаа тус байгууллага дээр давхар мэдээллийн сан үүсгэж байгааг өөрчилж, цаашид бүртгэлийн мэдээллийн санг ашиглах хүсэлтээ гаргасан байгууллагад мэдээллийг “view” хэлбэрээр ашиглуулах боломжийг судалж байна. Oracle backup recovery буюу мэдээллийн санг нөөцлөх тохиргоо, бүтэн нөөцлөлтийг сар бүрийн 30-ны өдөр, өөрчлөлтийн нөөцлөлтийг хоногт 1 удаа хийгдэж байхаар тохируулсан нь хэвийн ажиллаж байна.

1.11. Үйл ажиллагааг тайлагнах ажлын хүрээнд

Улсын бүртгэлийн үйл ажиллагааг тайлагнах ажлын хїрээнд дараах тайлан мэдээг холбогдох байгууллагад хүргүүлэн ажиллав. Үүнд:

- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтийн тайланг 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний хагас жилийн байдлаар;
- Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн тайланг 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний хагас жилийн байдлаар;
- 2014 оны ХАСХОМ-ийн нэгдсэн тайлан;
- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тайланг 2015 оны эхний хагас жилийн байдлаар;
- Холбогдох эрх зүйн актын биелэлтийг 2015 оны эхний хагас жилийн байдлаар;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын 2015 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт;
- 2013-2016 онд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний 2015 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт;
- Терроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2015 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлт;
- Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд УБЕГ-ын 2015 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилт;
- Өргөдөл, гомдол, санал, хүсэлт, шийдвэрлэсэн байдлын талаарх сар бүрийн мэдээ;
- Улсын бүртгэлийн үйлчилгээний талаарх сар бүрийн тоон мэдээ;
- Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын явцын талаарх сар бүрийн мэдээ.

ХОЁР. УЛСЫН БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1. Иргэний улсын бүртгэл хөтлөх хүрээнд

Иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр:

Тус газарт 2015 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар төрсний бүртгэл 34417, гэрлэлтийн бүртгэл 7152, гэрлэлт цуцалсны бүртгэл 1742, үрчлэлтийн бүртгэл 691, эцэг тогтоосны бүртгэл 12342, овог, эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 1589, нас барсны бүртгэл 7887 тус тус хийгдсэн байна.

Тайлангийн хугацаанд дараах нөхөн бүртгэлийг иргэний бүртгэл, мэдээллийн санд тусгаж, баталгаажуулав. Үүнд: төрсний нөхөн бүртгэл 1010, регистрийн дугаар өөрчлөлт 1930 /хяналтын байцаагчийн дүгнэлтээр 1063, улсын бүртгэгчээс үйлдсэн регистрийн дугаар солих

маягтаар 867/, эцэг тогтоолтын нөхөн бүртгэл 15, үрчлэлтийн нөхөн бүртгэл 47, гэрлэлтийн нөхөн бүртгэл 1087, гэрлэлт цуцлалтын нөхөн бүртгэл 120, овог нэр өөрчилсний нөхөн бүртгэл 28, нас баралтын нөхөн бүртгэл 5310, нэрийн сан 708 нийт 10255 бүртгэлийг иргэний бүртгэл, мэдээллийн санд тусгаж, баталгаажуулав.

Гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн чиглэлээр:

2015 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар гадаадын иргэний гэр бүлийн байдлын бүртгэлтэй холбоотой 316 хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ. Үүнд: гэрлэлт 102, гэрлэлт цуцалсан 57, холимог гэр бүлд төрсөн хүүхдийн бүртгэл 107, эцэг тогтоолтын бүртгэл 50 тус тус хийгдсэн.

Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас ирүүлсэн албан бичгийн дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоосон 2, харьяатаас гарсан 83, харьяат болсон 2 иргэнийг иргэний бүртгэл, мэдээллийн санд бүртгэв.

Иргэний шилжилт хөдөлгөөний чиглэлээр:

“Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын дагуу 5 сарын 30-ны байдлаар аймаг, хотоос шилжин явсан иргэд 20179, шилжин ирсэн 20210 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэлд бүртгүүлсэн байна.

Гадаадад зорчих эрхийн бүртгэлийн чиглэлээр:

2015 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар нийт 71524 үндэсний энгийн гадаад паспортыг шинээр олгож, 39591 иргэний үндэсний энгийн гадаад паспортын хугацааг сунгаж, нийт 111115 иргэнд энэ чиглэлээр үйлчилсэн байна.

Иргэний үнэмлэх хэвлэлтийн чиглэлээр:

Иргэний үнэмлэх хэвлэх ажлыг тодорхой, тогтмол болгох зорилгоор аймаг, нийслэл, дүүргийн бүртгэлийн газар, хэлтсээс иргэний үнэмлэх хэвлүүлэх мэдээллийг 7 хоногт хоёр удаа татан авч хэвлэж, иргэдэд чирэгдэлгүй, түргэн шуурхай үйлчлэх нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2015 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар нийт 88723 иргэний үнэмлэх олгосон бөгөөд үүнээс шинээр 21385, иргэний үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгасан 38408, дахин 28930 иргэний цахим үнэмлэх тус тус олгосон байна.

Иргэний шинэчилсэн бүртгэлд 2015 оны эхний хагас жилд 57008 иргэн хамрагдсан бөгөөд нийт 2140164 бүртгүүлснээс хилийн чанадад 40147, нийслэлд 884514, орон нутагт 1215503 иргэн хамрагдсан байна.

Монгол Улсын 3 сая дахь иргэнийг тодруулах ажлын хүрээнд:

Монгол Улсын 3 сая дахь иргэн, түүний чацуутнуудыг тодруулах ажлын хүрээнд Үндэсний статистикийн хороо болон УБЕГ-ын мэдээллийн сан дахь төрөлт, нас баралтын тоог 2014 оны сар бүрээр, 2010-2013 онд төрсөн хүүхдийн тоо, нас баралт, мөн Монгол Улсын хүн амыг насны бүлгээр тулгаж нягтлах мэдээлэл боловсруулах ажлыг зохион байгуулж, Монгол Улсаас гадаад улсад суугаа консулын газарт хийгдсэн төрөлт, нас баралтын бүртгэлийг 2013, 2014 оноор гаргаж, 2015 онд бүртгэгдсэн төрөлт, нас баралтын

бүртгэлийн талаарх мэдээг 7 хоног тутамд ҮСХ-нд хүргүүлж холбогдох мэдээ, мэдээллээр шуурхай хангаж ажилласан.

2.2. Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Тайлангийн хугацаанд шинээр байгуулагдсан 5004 хязгаарлагдмал хариуцлагатай компани, 1 хувьцаат компани, 7 орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 65 төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар, 122 нөхөрлөл, 111 хоршоо, 15 хадгаламж зээлийн хоршоо, 1125 төрийн бус байгууллага, 93 үйлдвэрчний эвлэлийн байгууллага, 74 сан, 16 шашны байгууллага, 44 хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 120 гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани, 2 гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл, нийт 6799 хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон бөгөөд 679 хуулийн этгээд татан буугдсан.

Хуульд заасан баримт бичгийг бүрдүүлж ирүүлсэн 199 хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газрыг бүртгэж гэрчилгээ олгосон.

Хуулийн этгээдийн нэр өөр хуулийн этгээдийн нэртэй давхардсан эсэх талаар мэдээллийн санд шалгаж 17508 хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалтыг хийлээ.

Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан улсын бүртгэлийн гэрчилгээг шинээр бичиж олгох, улсын бүртгэлийн жагсаалтад хөтлөх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж 87 хуулийн этгээдийг хамрууллаа.

Тайлангийн хугацаанд 7433 хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт өөрчлөлт орсныг улсын бүртгэлийн жагсаалт болон цахим санд хөтөлж, улсын бүртгэлийн гэрчилгээнд нь холбогдох бичилтийг хийж баталгаажууллаа.

Улсын бүртгэлийн гэрчилгээгээ үрэгдүүлсэн 953 хуулийн этгээдийн баримт бичгийг хүлээн авч хянан үзээд дахин улсын бүртгэлийн гэрчилгээ олгосон.

Гадаадын хөрөнгө оруулагч нарт 1002 цахим тодорхойлолт олголоо.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдсантай холбогдуулан Жижиг, дунд үйлдвэрийн тухай болон Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт орж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний бүртгэл Аж үйлдвэрийн яаманд 2015 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс шилжүүлсэн.

Үйл ажиллагааны тайлангаа ирүүлээгүй 16174 төрийн бус байгууллага, сангийн судалгааг гаргаж Сангийн яам, Татварын ерөнхий газарт хүргүүлж, санхүүгийн тайлангаа ирүүлээгүй жагсаалтыг яаралтай ирүүлэхийг санал болгосон.

Шашны байгууллагын 1, 2 дугаар улирлын мэдээ, судалгааг гарган Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

2.3. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтлөх хүрээнд:

Тайлангийн хугацаанд улсын хэмжээнд эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхээ бүртгүүлэхээр иргэн, хуулийн этгээдийн гаргасан 163913 мэдүүлгийг хүлээн авч, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэсэн байна.

Үүнээс: Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн анхны бүртгэл 19943, төрөөс үнэгүй хувьчилсан орон сууцны өмчлөх эрх баталгаажуулалт 328, төрөөс үнэгүй хувьчилсан газар өмчлөх эрхийн анхны бүртгэл 16582, төрөөс худалдаж авсан газрын өмчлөх эрх баталгаажуулалт 9, газар эзэмших, ашиглах эрхийн анхны бүртгэл 213, худалдах, худалдан авах гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл 8023, бэлэглэх гэрээгээр өмчлөх эрх шилжсэн бүртгэл 4734, барьцааны гэрээ 53080, өв залгамжлах эрхийн бүртгэл 1615, хамтран өмчлөгч өөрчлөгдөх гэрээ 4740, бусад бүртгэл 54646 тус тус бүртгэгдсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын цаасан баримтын цахимжуулалт хийгдээгүй 13 аймагт цахимжуулалт хийхэд шаардлагатай санхүүжилтийг “Ухаалаг засаг” төсөлд 2013 онд тусгуулсан ба 2015 оны 05 дугаар сарын 14-ны өдөр Ухаалаг засаг төслийг санхүүжүүлэгч Дэлхийн банкны төлөөлөлтэй УБЕГ-ын удирдлагууд уулзалт зохион байгуулсан. Уг төслийг 5 дугаар сарын 26-ны өдрийн УИХ-ын төсвийн байнгын хорооны хурлаар, 6 дугаар сарын 02-ны өдрийн Гадаад бодлого, аюулгүй байдлын байнгын хорооны хуралдаанаар төсөл дэмжигдсэн.

Аймаг, орон нутгаас ирүүлсэн холбогдох материалыг үндэслэн УБЕГ-ын даргын 38 удаагийн тушаалаар 38 хувийн хэргийг хааж, 7 удаагийн тушаалаар 14 хувийн хэргийг нэгтгэж, хүчингүйд тооцох тухай 49 тушаалаар 156 иргэний гэрчилгээг зохих журмын дагуу хянан шийдвэрлэсэн.

Үл хөдлөх эд хөрөнгийн зах зээлийг дэмжих, шаардлагатай мэдээллээр хангах, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор эд хөрөнгийн бүртгэлийн улсын статистик мэдээллийн мэдээ тайланг гаргаж орон сууцны мэдээг Монгол банкинд хүргүүлж байна.

ГУРАВ. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ, ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1. Бүртгэлийн хяналтын ажлын хүрээнд:

Тайлангийн хугацаанд үндэсний энгийн гадаад паспортын баримт бичиг, эзэмших, хадгалах журам зөрчсөн үндэслэлээр 5168 иргэнд торгуулийн арга хэмжээ авч, улсын төсөвт нийт 57001000 төгрөгийн орлогыг төвлөрүүлэв.

Бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэх зорилгоор хяналтын улсын байцаагчийн нийт 91 дүгнэлт үйлдэж, төв, орон нутгийн хяналтын улсын байцаагч нарын 539 дүгнэлтийг цахим санд хянан баталгаажуулж, 140 иргэн, 75 хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 426 зөрчлийг залруулж, хариу өгч ажиллав.

Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5.1 дэх заалтыг мөрдлөг болгон 66 иргэний гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлж, 217 иргэний гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлснийг сэргээсэн байна. Үүнээс прокурорын зөвшөөрөл бүхий хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан бичгийн дагуу 41 иргэний, гадаад паспорт авах зорилгоор бусдад баримт бичгээ ашиглуулсан, ашигласан, авахыг завдсан 25 иргэний гадаадад зорчих эрхийг хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр тус тус түр хугацаагаар түдгэлзүүлж, мөн хууль хяналтын байгууллагаас ирүүлсэн албан

бичгийн дагуу 145 иргэний, хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр 72 иргэний гадаадад зорчих эрхийг түр хугацаагаар түдгэлзүүлснийг тус тус цуцалсан байна. Улсын бүртгэлийн үйл

ажиллагаанд гарч буй бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэх зорилгоор хяналтын улсын байцаагчийн нийт 91 дүгнэлт үйлдэж, төв, орон нутгийн хяналтын улсын байцаагч нарын 539 дүгнэлтийг цахим санд хянаж, баталгаажуулсан байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу хууль зөрчсөн 9 хуулийн этгээдэд захиргааны арга хэмжээ авч, 1920000 төгрөгийн торгууль ногдуулж, бүртгэлийн зөрчлийг арилгав.

УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Багахангай, Сонгинохайрхан дүүргийн бүртгэлийн хэлтсийн улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалт, 2015 оны төлөвлөгөөт шалгалтыг Дархан-Уул, Орхон, Булган, Дундговь, Өмнөговь аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйл ажиллагаанд хийж, шалгалтын мөрөөр зөрчил дутагдалыг арилган ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд Нийслэлийн СБД, БГД, СХД, ХУД, ЧД, БЗД, Багануур дүүрэг, Багахангай дүүрэг, Налайх дүүрэгт нийт 12 удаагийн эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр дотоод хяналт шалгалт хийсэн. Түүнчлэн Баянхонгор аймаг, Сэлэнгэ аймгийн Мандал Сум, Завхан аймгийн Тосонцэнгэл сум болон Нийслэлийн Багануур, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн бүртгэлийн хэлтсийн 2015 оны 1 дүгээр улиралд боловсруулсан эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 512 мэдүүлгийг түүвэрчлэн авч шалгасан.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын ажлын хүрээнд:

Тус газар нь хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- УБЕГ-ын 2014 оны ийл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар, 2015 оны үйл ажиллагаанд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг Хууль зүйн яаманд хиргүүлсэн;
- Ерөнхий газрын дотоод газар, хэлтсийн 2014 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, холбогдох арга хэмжээг авсан.
- Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2014 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүнг Ерөнхий газрын Даргын зөвлөлд танилцуулж, холбогдох арга хэмжээг авсан.
- Улсын бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд 2014 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.
- УБЕГ-ын 2014 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтэд 2014 оны жилийн эцсийн байдлаар, УБЕГ-ын 2015 оны гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, төлөвлөгөөний биелэлтийг Хууль зүйн яаманд хиргүүлсэн.
- Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын биелэлтэд 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.
- Үндэсний хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд 2014 оны жилийн эцэс, 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.
- Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

- Холбогдох эрх зүйн актын биелэлтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.
- Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.
- УБЕГ-ын бичиг хэрэг, баримт бичгийн стандартын хэрэгжилтэд 2015 оны I улирлын байдлаар хяналт-шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.
- Хууль зүйн сайдын шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар, Хууль зүйн сайдаас өгсөн албан даалгаварын биелэлтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.
- УБЕГ-ын даргын үр дүнгийн гэрээний биелэлтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.
- УБЕГ-ын 2015 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд 2015 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, биелэлтийг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Тус газар нь дотоод аудитын чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- УБЕГ-ын даргын 2015 оны 883, 888 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Өмнөговь, Орхон, Булган аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2014, 2015 оны эхний улирлын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж, түүний мөрөөр холбогдох арга хэмжээг авч ажилласан.
- УБЕГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу “УБТАГ-ын Иргэний баримтын архивын цахимжуулалтын үйл ажиллагаа”-нд дотоод аудит хийж, холбогдох арга хэмжээг авч ажилласан.
- Улсын бүртгэлийн ерөнхий газар, дотоод газар, хэлтэс, аймаг, нийслэлийн Улсын бүртгэлийн газар, хэлтсийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийсэн.
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.
- Үндэсний аудитын газраас УБЕГ-ын газар, хэлтсүүдийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, илэрсэн зөрчлүүдийг арилгах үүднээс өгсөн зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

ДӨРӨВ. АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

4.1. Улсын бүртгэлийн архивын ажлын хүрээнд:

Тайлангийн хугацаанд иргэний бүртгэлийн чиглэлээр иргэд байгууллагад нийт 75000 лавлагаа, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр нийт 7553 лавлагаа, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр 6909 лавлагааг тус тус олгосон байна.

Архивын сан бүрдүүлэлтээр иргэний бүртгэлийн 126 хадгаламжийн нэгж буюу 75184 ширхэг буюу хуудас баримт, хуулийн этгээдийн бүртгэлийн 6657 хувийн хэрэг, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 37272 хувийн хэрэг, нийт 44055 хувийн хэрэг шинээр хүлээн авч архивын санд байршуулсан бөгөөд 2015 оны эхний хагас жилийн байдлаар улсын бүртгэлийн архивт

иргэний бүртгэлийн нийт 17806 хадгаламжийн нэгж, хуулийн этгээдийн 146374 хувийн хэрэг, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 751298 хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна.

Иргэний баримтын архивын цахим санд оруулсан 1951-1988 оны иргэний гэр бүлийн байдлын бүртгэлийн хадгаламжийн нэгжээс “Мэдээлэл удирдах систем”-ийг ашиглан лавлагаа олгож байна.

Архивын баримтын нөхөн бүрдүүлэлтээр ирүүлсэн иргэний гэр бүлийн байдлын болон иргэний бүртгэлийн ажилбар хийгдэх материалаас 88476 ХААТР маягтыг нэрийн эхээр ангилан ялгаж, 89005 цагаан толгойн үсгийн дарааллаар галиглан, 1253824 ширхэг ХААТР маягтыг нэгтгэж, 3398 маягтыг буцаан байрлуулж, 42545 баримтыг хувийн хэргийн нэгдсэн санд нэмж байрлуулсан.

2009 оноос өмнө бүртгэгдсэн шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй Төрийн бус байгууллага, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, Үйлдвэрчний эвлэлийн байгууллага, Шашны байгууллагын нийт 2650 хувийн хэргийг харьяалалын дагуу аймаг, дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэст шилжүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчлэгдсэнтэй холбоотойгоор Цагдаагийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдийн тамга, тэмдэг, баталгааны тэмдэгтэй холбоотой архивын 60 хадгаламжийн нэгж, 6 бүртгэлийн журналын баримт бичгийг хүлээн авч, архивласан.

Мөн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчийн бүртгэлтэй холбоотой архивын баримт /50 ширхэг хадгалалмжийн нэгж/-ыг Аж үйлдвэрийн яамд хүлээлгэн өгөхөд бэлэн болгоод байна.

Байгууллагын архивын хөтлөх хэргийн 2009 оноос 2013 оны түр хадгалах, 70 жил хадгалах, байнга хадгалах болон устгах хэргийн жагсаалтуудыг ҮАЕГазрын “Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комисс”-ын хуралдаанаар оруулахаар жагсаалтыг бэлэн болгосон.

4.2. Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн ажлын хүрээнд:

Тус газар нь иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг <https://burtgel.gov.mn> цахим хуудас дахь “Зочны дэвтэр”, “Онлайн лавлах 1800-1890” мессенжер, фэйсбүүк хаяг, “Бүртгэлийн нэгдсэн лавлах утас 1800-1890”, “иргэнд ээлтэй утас 70122014”, Засгийн газрын www.zasag.mn цахим хуудас дахь “11-11 мэдээллийн төв” болон бичгээр тус тус хүлээн авч хуулийн хугацаанд зохих журмын дагуу шуурхай шийдвэрлэн хариу өгч ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд тус газарт иргэд байгууллагаас нийт 4664 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлсэнээс бичгээр 2826, 11-11 төвөөр 134, цахим хэлбэрээр 139, утсаар 306, биечлэн уулзсан 1257, бусад хэлбэрээр 2-г тус тус ирүүлсэн бөгөөд үүнээс санал хүсэлт-1767, гомдол-251, өргөдөл-2646 тус тус ирүүлснийг тухай бүрт нь шийдвэрлэж, иргэдэд хариу өгч ажилласан, шийдвэрлэлтийн байдал 100 %-тай байна.

Тус газарт нийт 18627 албан бичиг ирсэнээс 12367 хариутай, шууд шилжүүлсэн 6260 албан бичиг байсан бөгөөд тус газраас бусад байгууллага, албан тушаалтанд хандаж нийт 7434 албан бичиг явуулсан байна.

~~oOo~~

ТАВ. ДҮГНЭЛТ

Тус газрын 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажил үйлчилгээг 58,51 хувийн биелэлттэйгээр хэрэгжүүлэн ажилласан байна.

Дээд газрын тогтоол, шийдвэр, үүрэг чиглэлийг үр дүнтэй хэрэгжүүлж, тайлан мэдээг тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлэн ажилласан.

Тайлангийн хугацаанд тус газрын шуурхай хурлыг 6 удаа, даргын зөвлөлийн хурлыг 5 удаа зохион байгуулж, цаг үеийн тулгамдсан болон бусад шаардлагатай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна. Мөн хугацаанд тус газрын даргын 1005 тушаал батлагдан гарсан байна.

Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах ажлын хүрээнд үйл ажиллагаа, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, хүний нөөцийн ил тод байдлыг ханган ажилласан байна.

Бүртгэлийн үйлчилгээг иргэдэд ойртуулах, тїргэн шуурхай, чирэгдэлгүй, хїртээмжтэй хїргэх ажлын хүрээнд тус газар нь нилээд ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

Энэхүү ажлын хүрээнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, аймгийн Засаг дарга нартай хамтран ажилласны үндсэн дээр хороодыг улсын бүртгэлийн нэгдсэн сүлжээнд холбох ажил амжилттай хэрэгжиж байна.

Түүнчлэн Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын цаасан баримтын цахимжуулалт хийгдээгүй 13 аймгийн хэмжээнд эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын нотлох баримтын цахимжуулалтын бэлтгэл ажлыг 2014 онд бүрэн дуусгасан. Орон нутгийн санхүүжилтээр Сэлэнгэ, Баянхонгор аймгуудад цахимжуулалтын ажил амжилттай явагдсан.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль шинэчилсэн найруулгаар батлагдаж, энэ оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан байгууллагын <https://burtgel.gov.mn/> цахим хуудас, хуулийн этгээдийн цахим бүртгэлийн програм хангамжийг ашиглан иргэдэд хуулийн этгээдийн нэр шалгах, захиалах, хуулийн этгээдийн мэдээлэлд өөрчлөлт оруулах, хуулийн этгээд шинээр үүсгэн байгуулах үйлчилгээг тус тус үзүүлдэг болсон.

2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг хуульд заасан хугацаанд аудитаар баталгаажуулж, санхүүгийн үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд үнэн бодитой тайлагнасан, “Зөрчилгүй” гэж дүгнэгдсэн.

Тус газар нь 2015 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, терроризмоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын төлөвлөгөө, Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн

хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сүүлийн хагас жилийн хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан бусад арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэн ажиллах болно.

~~oOo~~